

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах	MNS 2418 : 2011 MNS 2418 : 1977-ийн оронд
Soil preparation of forest nurseries	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь мод үржүүлгийн газрын хөрсийг хагалах, сийрүүлэх, булдаж нягтруулах, тэгшлэх зэрэг хөрс боловсруулах ажилд хамаарна.

2. Хөрс боловсруулах

Хөрсийг хөнгөн сэвсгэр, үрлэн бүтэцтэй болгох, ус агаарын горимыг тохиромжтой байлгах, шим тэжээлийн бодисын хуримтлалыг дээшлүүлэх, хөл газрын ургамал, өвчин хорлогчидыг устгахын тулд хөрсийг боловсруулдаг.

2.1 Хөрсийг доорх үндсэн хэлбэрээр боловсруулна.

2.2 Хагалгааг анжисаар шан ба хамар үүсгэлгүй хагалахад жигд бутарч талбайн гадаргуу тэгш болж гуурсны үлдэгдлүүд доод давхаргаанд сайн булагдан ялзмаг үүсэх боломж бүрддэг.

2.3 Сэндэчлэгээ – Агро техникийн шаардлагаас хөмрөлттэй ба цант сэндэчлүүрээр 6-14 см гүнд хийнэ. Хөмрөгч сэндэчлүүр нь хөрсийг сийрүүлэн хөл газрын ургамлыг огтолж хөрсний өнгөн үеийг хөмрүүлнэ.

2.4 Борнойдолт - Хагалгааны дараа хөрсийг сийрүүлэн тэгшлэх, хөрсний өрөмтлийг устгах, агаарын солилцоог сайжруулах, хөрсний том хэсгийг бутлах, чийгийн ууршилтыг багасгадаг.

2.5 Сийрүүлэлт - Хөрсний том хэсгийг бутлах, хөл газрын ургамлыг устгах өнгөн давхаргыг зөөллөх, агаарын солилцоог сайжруулах зэргээр үр суулгах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэхээр хөрсийг 6-аас 12 см-ийн гүнд зохих хугацаанд сийрүүлсэн байна.

2.6 Булдалт – Хөрсний чийгийн алдагдлыг багасгаж, хөрсний халалтад сайн нөлөө үзүүлнэ. Бул нь шинэхэн хагалсан хөрсний 10 см-ийн гүн хүртэл нягтруулсан байна.

3. Хөрс элдэншүүлэлт

3.1 Мод үржүүлгийн газар байгуулахаар сонгож авсан талбайн элдэв хог, чулуу, мод, бутыг үндэсээр нь булгалан зайлуулж хотгор гүдгэрийг зассаны дараа хөрсийг элдэншүүлнэ.

MNS 2418 : 2011

3.2 Атар ба атаржсан газрыг тарилт эхлэхээс 1-ээс 2 жилийн өмнө хөрсийг хагалж чийг тогтоох хог ургамал өвчин үүсгэгчийг устгах тэжээлийн бодис хуримтлуулах нөхцөлийг хангаж уриншилсан байна.

3.3 Атар ба атаржсан газрыг хавар эрт 5-р сард 5-аас 6 см-ийн гүнд сэндэчлэн дараа нь нэг ба олон наст хог ургамлыг жигд соёолсон үед хөрсний агрохимийн бүтцээс хамааруулан 6-р сард бул борнойтой агрегаталсан анжисаар 22-оос 25 см гүн хагалж уриншилсан байна.

3.4 Уриншилсан талбайг зуны турш цэвэр байлгахын тулд сийрүүлэх ба сэндэчлэгээг 8-аас 10 см гүнд хийж борнойдох өнгөн элдэншүүлгийг 3-аас доошгүй хийсэн байна.

3.5 Хөнгөн элсэрхэг хөрстэй талбайг борной агрегатаар элдэншүүлэн булдсан байна.

3.6 Атар ба атаржсан газрын 2 дахь жилийн элдэншүүлэлтийг 7-оос 8-р сараас ойн зурвас ба плантаци байгуулах талбай, бойжуулах хэсгийн хөрсийг хөрслүүргүй анжисаар 30-аас 40 см гүн хагалсан байна.

3.7 Цэвдэгш хагалгааг борной булын зохицолдоотой хөрслүүртэй анжисаар 9-р сард багтааж 27-оос 30 см, бойжуулгын хэсэгт 40-өөс 50 см гүн хагалсан байвал зохино.

3.8 Хавар чийг хаах борнойдолтыг 4-р сарын эхээр хийсэн байна.

3.9 Хэвгий газрын хөрсийг элдэншүүлэхдээ хөндлөн чиглэлд, хагалагдах давхаргын гүнд тохируулан 25-аас 40 см хагалгааг хийнэ.

3.10 5 градусаас дээш налуутай бол 140-өөс 175 см зайд хамар гарган хөрсийг элдэншүүлвэл зохино.

3.11 Үрийг тарихын өмнө хавар хөрс 7-оос 8 см гэссэн үед чийг хаах борнойдолтыг хагалгааны хөндлөн чиглэлд хийнэ. Хөнгөн хөрсийг үр тарихын өмнө, хойно булдна.



Зураг. Хөрс боловсруулалт

ТӨГСӨВ.